



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,  
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170

Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,

Цахим шуудан: contact@afccp.gov.mn,

Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024-06-24 № 01/1221

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тендерийн баримт бичиг  
хянасан тухай**

Танай компаниас зарласан “Хориг хашаа” МТЗ/20240102145 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт “Дорнын харгуй” ХХК-аас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хяналаа.

Тендерийн баримт бичгийн 19.1-д “...Техникийн чадавх болон туршлагын шаардлага: “Шаардана”. Ажил гүйцэтгэх хүний нөөц: “Шаардана” Хориг хашаа барьж, байгуулах гүйцэтгэгч нь мэргэжлийн инженер, техникийн ажилчид бүхий хүний нөөцтэй байна. Үүнд: - Ерөнхий инженер 1 хүн, - ХАБЭА-н инженер 1 хүн, - Газар зохион байгуулалтын инженер 1 хүн, - Барилгын инженер 1 хүнийг тус тус үндсэн ажилтнаар ажиллуулдаг байх бөгөөд сүүлийн 1 жил тасралтгүй нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх. Туршлагын шаардлага нь: Ерөнхий инженер нь мэргэжлээрээ 5-аас доошгүй жил, ХАБЭА-н инженер, Газар зохион байгуулалтын инженер, Барилгын инженер нь мэргэжлээрээ 1-ээс доошгүй жил тус тус ажилласан байх, Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: “Шаардана” - Портер – 1ш, - Крантай машин 16тн даацтай – 1ш, - Үйлчилгээний жижиг тэрэг – 1ш, - Нүх ухдаг механизм – 1ш ... Дээр дурдсан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нь өөрийн эзэмшлийнх байх; Мөн металл хийцийг бэлтгэх өөрийн эзэмшлийн үйлдвэрлэлийн цехийн барилгатай байх;” гэж тус тус заасан байна.

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/259 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн 19.1-т “Техникийн чадавх болон туршлагын шаардлага: [“Шаардана” эсхүл “Шаардахгүй” аль нэгийг сонгож бичнэ. Хэрэв шаардах бол дор дурдсан шаардлагаас гэрээний үүргийн гүйцэтгэлд ач холбогдол бүхий шаардлыг тусгах ба үүгээр хязгаарлагдахгүй.], Ажил гүйцэтгэх хүний нөөц: [“Шаардана” эсхүл “Шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бичих. Хэрэв шаардах бол уг ажлыг гүйцэтгэх удирдах, хяналт тавих, тодорхой ажил, үйлчилгээг гүйцэтгэх ажилтан, ажилчдын боловсрол, мэргэжлийн ур чадвар, туршлагын талаар шаардах мэдээллийг тодорхой бичих], Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: [“Шаардана” эсхүл “Шаардахгүй” гэдгээс аль нэгийг сонгож бичих. Хэрэв шаардах бол тухайн ажил гүйцэтгэхэд зайлшгүй шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгсэлд тавигдах шаардлагыг тодорхой заана.]” гэж заасан байна.

0002710

Тус тендер шалгаруулалтын баримт бичиг нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална" гэж, 17 дугаар зүйлийн 17.2-т "Техникийн чадавх, туршлагын талаарх мэдээллийг дараах баримт бичгээр нотолж болно:" гэж, 17.2.3-т "гэрээний үүргийн гүйцэтгэлийг хариуцах ажилтны нэр, боловсрол, мэргэжлийн ур чадварын мэдээлэл," гэж, 17.2.4-т "гэрээний үүргийг гүйцэтгэхтэй холбоотой машин механизм, тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн байрны мэдээлэл;" гэж тус тус заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу "Хориг хашаа" МТЗ/20240102145 дугаартай тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулна уу.

ДАРГА



Б.БИЛГҮҮН